



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 1/88

Номгон

Аймгийн төрийн байгууллагын дарга
нарын ажлын цаг ашиглалтыг сайжруулах,
талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай” 03 дугаар албан даалгаврын 1.4, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Чадахуйн зарчимд суурилсан хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн үйлчилгээг хүргэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг чангатгах зорилгоор сум, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарын ажлын цаг ашиглалтыг сайжруулсугай.

2. Ажлын цаг ашиглалт, бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд цаг бүртгэлийн “Timely.mn” нэгдсэн системээр нийт төрийн байгууллагын дарга, сумын Засаг дарга нарын ажлыг цагийг 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн бүртгэсүгэй.


3. Мэдээллийг “Timely.mn” системд бүртгэж, төрийн байгууллагын удирдах албан тушаалтнуудыг систем ашиглалтын зөвлөгөө, зааварчилгаагаар ханган, хяналт тавьж, өдөр тутмын мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д, ажлын цагаа тогтмол бүртгүүлж ажиллахыг нийт сум, байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

4. Систем хариуцагч байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан, нэг сарын төлбөр болох 501,270 (Таван зуун нэг мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын

даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ